



# iPhone

Утас идэвхжүүлэх тохиргоо  
iOS 8.4 үйлдлийн систем

- iTunes, iCloud гэж юу вэ?
- Утсаа идэвхжүүлэх, тохиргоо хийх
- Apple ID нээх
- Интернэтэд холбогдох
- И-мэйл тохиргоо хийх
- Сүлжээ хайлгах
- Интернэт, видео дуудлага
- Дуудлагын тохиргоо хийх
- Гар утсыг цоожлох, нууц үг оруулах

## iTunes, iCloud гэж юу вэ?

iTunes гэдэг нь Apple брэндийн iPhone, iPad, iPod гэх мэт төхөөрөмжийг дэмжин ажилладаг програм бөгөөд тус програмын тусламжтайгаар та өөрийн төхөөрөмжид төрөл бүрийн контент, аппкейшн, дуу, телевизийн шоу, кино гэх мэт бүхий л хэрэгцээт зүйлсийг татан авахаас гадна өөрийн компьютерт байгаа зураг, дуу, клип гэх мэт зүйлсээ хуулан авах боломжтой.


iCloud нь хэрэглэгчийн контентийг хамгаалах, хэрэглэгч өөр хоорондоо өндөр хурдаар контентоо дамжуулах боломжийг олгож буй cloud буюу үүлэн тооцоолуурт суурилсан технологи юм.

Apple-ийн бүх хэрэглэгч iCloud үйлчилгээг ашиглах боломжтой бөгөөд мэдээллийг агуулах хэмжээнээс шалтгаалан үнийн шатлал өөр байдаг.

5GB хүртлэх мэдээллийг агуулах эрх бүх хэрэглэгчид нээлттэй бөгөөд түүнээс илүүг ашиглахыг хүсвэл нэмэлт төлбөр төлөн ашиглах боломжтой.

## Утсаа хэрхэн идэвхжүүлэх вэ?


















iPhone 5 болон түүнээс сүүлд гарсан загварын гар утсанд Nano Sim /жижиг SIM карт/ ордог тул үйлчилгээний төвд хандаж SIM картаа солиулж ашиглана.



Та өөрийн гар утсаа Wi-Fi болон 3G сүлжээг ашиглан идэвхжүүлэх боломжтой. Мөн гар утсаа iTunes-д холбогдсон компьютерт холбон идэвхжүүлж болно.

Гар утсаа асаан дэлгэцэнд гарах зааврын дагуу тохиргоог хийнэ. (Зураг 1)

1. Хэл, Улс сонгох
2. Wi-Fi эсвэл 3G интернэт сүлжээнд холбогдох
3. Бүртгэлтэй Apple ID-гаар нэвтрэх болон шинээр хаяг нээн нэвтрэх боломжтой. (Apple ID нь цаашид Facetime, iCloud, App Store, iTunes store гэх зэрэг олон үйлдэлд ашиглагдана.)
4. Нууц үгээ оруулна iCloud тохируулах. (iCloud Keychain нь монголд ашиглах боломжгүй тул зөвхөн iCloud-д холбогдох)
5. Байршил тодорхойлогч гэх мэт бусад онцлох сонголтуудыг идэвхжүүлж болно.
6. Сүлжээ орж утас идэвхжинэ.
7. Мөн та өмнө нь iCloud болон iTunes-д хэрэгцээт мэдээллээ хуулж байсан бол шинэ утсандаа мэдээллээ татан авах боломжтой.



## Apple ID үүсгэх

Гар утсанд контент, аппликейшн, дүү, телевизийн шоу, кино гэх мэт бүхий л хэрэгцээт зүйлсийг татан авахад ашиглагдах хаяг юм. Дараах хаягаар орж Apple ID шинээр үүсгэх боломжтой. /<https://appleid.apple.com/>

Та iPhone, iPad, эсвэл iPod гэх мэт өөрийн төхөөрөмжөөс Apple ID үүсгэх бол.

### (Зураг 2)

1. Төхөөрөмжөөс App Store, iTunes Store болон iBooks-ийн аль нэг цэсийг нээнэ.
2. Үнэ төлбөргүй /free/ аппликейшн, дүү, бичлэг болон номыг сонгоно.
3. Get товчийг дараад дахин INSTALL товчийг дарна.
4. Дэлгэцэнд дээр Apple ID-аар нэвтрэх, шинээр Apple ID үүсгэх сонголт гарч ирнэ.
5. Шинээр Apple ID нээх бол /Create New Apple ID/
6. Улс сонгоно /Mongolia/
7. Нөхцөл /Terms and Conditions and Apple Privacy Policy/ хэсэгт орж Agree буюу зөвшөөрөх сонголтыг сонгоно.
8. APPLE ID AND PASSWORD

Email: нэвтрэх и-мэйл оруулж өгнө. Жишээ нь: Boldoo111@gmail.com эсвэл yahoo гэх мэт идэвхтэй и-мэйлээ оруулна.

Password: Том, жижиг үсэг болон тоо оруулсан 8 буюу түүнээс дээш тэмдэгтийг агуулсан нууц үг зохионо.

Verify: Password хэсэгт бичсэн нууц үгээ баталгаажуулж дахин оруулна.

9. Security info: Нууцлалын мэдээлэл.

Question: Асуулт

Answer: Хариулт

Та нууцлалын 3 асуултанд хариулах шаардлагатай ба хариултаа мартаж болохгүй. Энэхүү хариултауд нь таны нууцлалыг нэмэгдүүлэх давуу талтай юм.













10. Optional rescue email: Та өөрийн /8-рт оруулсан/ имэйлээс өөр и-мэйл оруулна. Та хариултаа энэ хаягт таны мэдээллийг шинэчлэн илгээх болно.

11. Төрсөн он сар өдрөө оруулна.

12. Billing information: Тухайн хэсгээс none сонголтыг дарна. /Төлбөргүй контент татахад ашиглана/

13. Billing address хэсгийн мэдээллийг бүгдийг бөглөнө.

14. Verify Your Account: Таны бүртгүүлсэн хаягт баталгаажуулах и-мэйл очино. Та ирсэн и-мэйлээр орж verify буюу баталгаажуулах сонголтын дарснаар таны сонгосон контент татагдах боломжтой болно.



## Интернэтэд холбогдох

Та гар утасныхаа Wi-Fi болон 3G сүлжээ ашиглан интернэтэд холбогдох боломжтой.

Wi-Fi сүлжээ ашиглан интернэтэд холбогдох

- Settings - Wi-Fi - Wi-Fi /идэвхжүүлэх/

3G сүлжээ ашиглан интернэтэд холбогдох

- Settings-Cellular-Cellular Data /идэвхжүүлэх/

Та Мобикомын дата багцын талаар мэдээлэл авах бол

**И-мэйл тохиргоо хийх**

- Settings - Mail, Contacts, Calendars - Add Account.

**Сүлжээ хайлгах:**

- Settings-Carrier-Automatic / автоматаар сүлжээгээ хайна/

**Дуудлага гарахгүй байгаа үед:**

- Settings- phone- Show My Caller ID/ идэвхжүүлнэ/

**Интернэт, видео дуудлага :**

- Settings-Cellular-Cellular Data /идэвхжүүлэх/

iPhone нь гар утасны сүлжээг ашиглан дүрст дуудлага хийх боломжгүй, харин Wi-Fi болон утасны интернэт сүлжээг ашиглан Facetime-аар дүрст дуудлага хийх боломжтой.

Settings-Facetime /идэвхжүүлэх/

**Гар утсыг цоожлох, нууц үг оруулах:**


- Settings-Passcode-Turn Passcode On-Нууц код дахин давтаж оруулах.

## Мобиком Корпораци ХХК-с iPhone утас худалдан авсны давуу тал:

1. Шүүд үйлдвэрээс ирдэг.
2. Баталгаат хугацаа 1жил.
3. Дагалдах хэрэгсэл 3 сарын баталгаатай.
4. 1 жил дотроо үйлдвэрийн ямар ч гэмтлийг бүрэн барагдуулна .
5. Програмын болон iOS дээр алдаа үүсэхэд үнэ төлбөргүй засвар үйлчилгээ үзүүлнэ .
6. Үнэгүй заавар зөвлөгөө өгөх болон iPhone-н сургалт явагддаг.

# iPhone гар утсаа засуулах гэж байгаа хэрэглэгч ирэхдээ юу юуг анхаарах вэ?

1. Хэрэглэгч баталгааны хуудсаа заавал авч ирэх шаардлагатай.
2. Утсан дахь Apple ID хаягаа iCloud хэсгээс гаргасан байх.
3. Хэрэглэгч утсанд байгаа мэдээллээ Apple ID хаягтаа Back up хийж хуулсан байх.
4. Манай албан ёсны засварын төвөөс бусад засвар үйлчилгээний төв болон хувь хүмүүсээр гар утасны сэлбэг хэрэгсэл сольсон, засуулсан тохиолдолд манай засварын төвд хамаарахгүй.

 **БАТАЛГААТ ЗАСВАРЫН ХУУДАС** № .....

1. Худалдан авагчийн нэр: \_\_\_\_\_

2. Гар утас/төхөөрөмжийн марк: \_\_\_\_\_

3. Гар утас/төхөөрөмжийн сериал дугаар: \_\_\_\_\_

4. Гар утасны дагалдах хэрэгсэл:  Чихэвч  Цэнэглэгч  Адаптор  Холбогч  Бусад

5. Гар утасны баталгаат хугацаа: \_\_\_\_\_

6. Гар утас/төхөөрөмж хүлээлгэн өгсөн ажилтны нэр: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

**Засварын тэмдэглэгээ**

1. Гэмтлийн онош: \_\_\_\_\_

2. Гар утас/төхөөрөмж зассан тэмдэглэгээ: \_\_\_\_\_

3. Үзлэг үйлчилгээ хийсэн инженер: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Худалдан авсан огноо: 20 . . . оны . . . -р сарын . . . -ны өдөр

1. Энэхүү баталгаат засварын хуудас нь Мобиком Корпораци ХХК-аас худалдан авсан гар утас, төхөөрөмжид хамаарна.

2. Хэрэглэгч гар утас засварын төвд хүчин төгөлдөр баталгаат засварын хуудсыг авчирсан тохиолдолд үйлчилгээ үзүүлнэ.

3. Баталгаат засварын хугацаанд тухайн утсыг сольж өгөхгүй ба гэмтсэн эд ангийг сольж, утсыг хэвийн ажиллагаанд оруулж өгнө. Энэ тохиолдолд баталгаат хугацаа хэвээр үргэлжилнэ.

4. Гар утас/төхөөрөмжийн засвар үйлчилгээ оношилгоог цаг тухайд нь түргэн, шуурхай үзүүлэх ба шаардлагатай тохиолдолд (сэлбэг эд ангийн нөөц болон гэмтлээс хамааран) ажлын 7-21 хоног хүртэлх хугацаанд гүйцэтгэнэ.

**Дараах тохиолдолд үнэ төлбөргүй засвар үйлчилгээ үзүүлэх боломжгүй**

1. Гар утсыг хэрэглэгчид хүлээлгэн өгсний дараа үүссэн механик гэмтэл /утас нүдэнд үл харагдахуйцаар хагарсан, хайлсан, цуурсан, ус чийг орсон/

2. Гэмтэл нь вирус түүнтэй адилтгах програмаас үүдсэн, мэргэжлийн бус аргаар код уншуулах, програм хангамжийн тохиргоог өөрчлөх эсвэл дахин суулгах, хуурамч програм хангамж суулгах зэрэг үйлдлээс үүдсэн,

3. Хэвийн элэгдэл хуучралттай холбоотой эвдрэл гэмтэл,

4. Баталгаат хугацаандаа эрх бүхий бус засвар үйлчилгээний төв хувь хүнээр засуулсан, засуулах гэж оролдсон,

5. Утсанд байрлуулсан баталгаат засварын лацыг хөдөлгөсөн, оролдсон, гар утасны сериал дугаар зөрсөн.

**Санамж**

1. Гар утасны батерей нь үйлдвэрээс төстийн цэнэгтэй ирдэг тул анхны цэнэглэлтийг бүрэн дүүртэл цэнэглэх шаардлагатай.

2. Батерей аль болох дүүртэл цэнэглэж дуустал нь хэрэглэвэл батерей төдий чинээ удаан хугацаанд хэрэглэнэ.

3. Гар утсыг 7 хоногт нэг удаа батерейг утаснаас салган авч буцаан хийн унтрааж асааж байвал таны утас гацахгүй хурдан ажиллах болно.

4. Хэрэглэгч гар утсан дахь хувийн мэдээллээ өөрөө урьдчилан хадгалсан байх шаардлагатай.